

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК-ий ХЭ-гчдийн ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 2024/01

Хурал хийсэн огноо: **2024.04.30.**

Хурал хийсэн газар: Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг, Бүрд зочид буудлын 2-р давхар

Хурал эхэлсэн хугацаа: **14.00 цаг**

Хурал зохион байгуулах комиссын дарга О.Мөнх-Эрдэнэ хурлыг нээж тооллогын комиссын дарга Ж.Түмэндэлгэр хурлыг ирцийг мэдээлэв.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1-дэх заалт, 69-р зүйлийн 69.1-дэх заалтыг тус тус үндэслэн **Тооллогын комиссын дарга Ж.Түмэндэлгэр:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд нийт 71,371 саналын эрх бүхий энгийн хувьцааны 52,612 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар оролцож нийт саналын 73,72% болж байгааг хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 73,72%-ийг эзэмшигчид хуралд саналын хуудсаа бөглөн оролцсон учир компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай. Гэсэн Тооллогын комиссын ТОГТООЛ дугаар 01-ыг уншиж танилцуулав.

О.Мөнх-Эрдэнэ:

Хэлэлцэх асуудал:

“Мандалговь-Импекс” ХК-ий 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны талаарх болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх;
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах
3. Бусад / нэмэлт хувьцаа гаргах эсэх тухай/
4. Дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Хурлын дэг:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх сонсгол, дүгнэлтийг хэлэлцэх /О.Мөнх-Эрдэнэ 10 мин/
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах /О.Мөнх-Эрдэнэ 3 мин/
3. Бусад / нэмэлт хувьцаа гаргах эсэх тухай/ О.Мөнх-Эрдэнэ 10 мин/
4. ХК-ий дүрмийн төслийг танилцуулан батлах /Д.Одгэрэл 5 мин/
5. Санал, шүүмжлэл /хүн тус бүр 2 мин/
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулах /О.Мөнх-Эрдэнэ 1 мин/

Хурлын явц:

1. Хэлэлцэх асуудлыг танилцуулж 100% саналаар батлав.
2. Хурлын дотоод журам, дэгийг танилцуулахад, санал нэгтгэйгээр батлав. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, саналаа тухай бүр гаргахаар шийдвэрлэв.
3. Хурлын дэгийн дагуу:

Нэг: Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх сонсгол, дүгнэлтийг О.Мөнх-Эрдэнэ танилцуулав.

С.Баярцэцэг: Тайлантай холбоотойгоор асуух асуулт байна уу?

О.Мөнх-Эрдэнэ: Энэ санхүүгийн тайлангийн аудитын компаныг хэн сонгосон юм.

Д.Одгэрэл: ГЗ Ц.Одгэрэл 2023 оны санхүүгийн тайланг “Дөлгөөн хайрхан уул аудит” ХХК-аар аудитын дүгнэлт хийлгэсэн. Ер нь бол Х тайлан гарсан. 2023 онд Хаан банкн дахь дансаа идэвхтэй болгох, Үйл ажиллагаа явуулахын тулд орчин цагийн шаардлагад нийцүүлэн тохитой орчин бүрдүүлэхийн тулд засвар хийх гол шаардлага байсан гэдгийг та бүхэн мэдэж байгаа.

О.Мөнх-Эрдэнэ: Өөр асуух асуулт байна уу. Байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалд орёё.

Хоёр: Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө С.Баярцэцэг танилцуулав.

С.Баярцэцэг: Төлөвлөгөөнд тусгах өөр санал байна уу?

О.Мөнх-Эрдэнэ: Барилга болон газрын өмчлөлийн талаарх түүхийг Улсын бүртгэлийн газраас авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг 2024 онд компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулж өгье.

С.Баярцэцэг: Улсын бүртгэлийн газраас Мандалговь-импекс ХК-ийн нэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн талаарх түүхийг өөрийн компанийн албан бичгээр хүсэлт гаргаж лавлагаа, тодорхойлолт авч, Үндсэн хөрөнгийг баримтанд тулгуурлан балансанд бүртгэх хэрэгтэй.

О.Мөнх-Эрдэнэ: Дэмжиж байна.

С.Баярцэцэг: Өөр санал байхгүй бол 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд дээрх ажлыг тусгая.

Гурав: Бусад / нэмэлт хувьцаа гаргах эсэх тухай Д.Одгэрэл танилцуулав.

О.Мөнх-Эрдэнэ: Манай ХК-ий үйл ажиллагаа явуулах гол байр бол Алтанговь зочид буудал. Үүнийг бүрэн шинэчилж засвар үйлчилгээ хийх шаардлагын үүднээс бид 2023 онд засвар хийлээ. Засвар хийхэд мөнгө хөрөнгө босгох шаардлага байгаа. Нэмэлт хувьцаа гаргах асуудлыг сайн судлаад 2025 онд шийдвэрлэх саналтай байна. 2023 онд дээврийн засал хийж, дотор засал маань 30%-ийн гүйцэтгэлтэй байгаа. Энэ бүгдийг хийхэд шаардагдсан мөнгөн хөрөнгийг О.Мөнх-Эрдэнэ миний бие гаргасан. Харин 2024 ондоо засвар хийх, дотор заслыг бүрэн болгож үйл ажиллагааг эхлүүлэх, гадна талбайн тохижилтын ажил гээд нэлээд хөрөнгө мөнгө шаардагдаж байгаа. ХЭ-гчид шаардагдаж буй мөнгөн хөрөнгөнд өөрсдийн хувь нэмрийг оруулж үйл ажиллагааг эхлүүлж орлого олохгүй бол бид нэлээд хэдэн жилээр үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрэхээр байна.

Д.Одгэрэл: Өөр санал байна уу. Байхгүй

Дөрөв: ХК-ий дүрмийн төслийг танилцуулан батлах

О.Мөнх-Эрдэнэ: Бид нэмэлт хувьцаа гаргах эсэх талаарх асуудлыг шийдвэрлэж, үүний үндсэн дээр ХК-ий дүрэмд өөрчлөлт оруулж, дүрмийн төслийг танилцуулах ёстой байсан. Нэмэлт

хувьцааг 2024 онд биш, 2025 онд гаргах эсэх талаар ярилцаж шийдвэрлэхээр хойшлуулсан тул ХК-ий дүрэмд өөрчлөлт оруулах, дүрмийн төслийг танилцуулах энэхүү хурлаар хэлэлцэх асуудал маань хойшлогдож байна.

Тав. Санал шүүмжлэл: Хэлэлцэж буй асуудал тус бүр дээр санал шүүмжлэлээ хэлээд явсан болно.

- Тооллогын комисс тус ХК-ий ХЭ-гчдийн ээлжит хуралд санал авах хуудсыг тарааж өгнө үү. Санал өгөх хуудас дээр ХЭ-гч та бүхэн саналаа өгч бөглөнө.
- Тооллогын комисс Санал авах хуудсыг хураан авч Саналын дүнг танилцуулав. Тооллогын комиссын ТОГТООЛ дугаар 02-ыг танилцуулав. Санал өгөх хуудас дээр ХЭ-гч та бүхэн саналаа өгч бөглөнө.

О.Мөнх-Эрдэнэ: Тооллогын комисс тоолж, саналын дүнг танилцуулна уу.

Ж. Түмэндэлгэр: Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 73,72% нь зөвшөөрсөн байна.

Зургаа: Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-дэх заалт, 2024 оны 4 сарын 30-ны өдрийн **ТООЛЛОГЫН КОМИССЫН** тогтоолыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2024 онд хэрэгжүүлэхээр танилцуулсан төлөвлөгөөг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг ГЗ Ц.Одгэрэлд үүрэг болгосугай.
3. 2025 онд “Мандалговь-Импекс” ХК-ий нэмэлт хувьцаа гаргах талаарх асуудлыг судалж хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллахыг ГЗ Ц.Одгэрэлд үүрэг болгосугай.
4. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:

ХЭ-гч О.Мөнх-Эрдэнэ

ХЭ-гч

ХЭ-гч

О.Мөнх-Эрдэнэ

С.Баярцэцэг

Д.Одгэрэл

Тэмдэглэл хөтөлсөн:

Д.Одгэрэл

